

## ГХЯ-ны “Шилэн дансны хууль”-ийн хэрэгжилтийн 2024 оны I улирлын тайлан

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3.2.3.6<sup>1</sup>, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 8.2<sup>2</sup>, 8.5<sup>3</sup>-д заасныг тус тус үндэслэн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагын “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийн явц болон нэгдсэн цахим хуудсанд үнэн зөв, цаг хугацаанд нь байршуулсан эсэхэд хяналт тавьж, үнэлгээ өгч, зөвлөмж хүргүүлэн эрсдэлийн удирдлагаар ханган ажиллав.

“Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.9<sup>4</sup>-д заасны дагуу шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай 2023 оны жилийн эцсийн товч тайланг Гадаад харилцааны яамны цахим хуудаст 2024 оны 2 дугаар сард байршуулсан болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 53 (ГХЯ, Гадаад харилцааны сайдын багц, ДТГ-ын төвийн тооцоо, ДБҮЭГ, ЮНЕСКО, ДТГ 48) байгууллагын шилэн дансны I улирлын тайланг Сангийн яамны “Шилэн дансны нэгдсэн цахим хуудас”-т байршуулж, тайлагнасан байдалд хяналт-шинжилгээ үнэлгээ хийв.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт I улирлын байдлаар **100.0** хувийн гүйцэтгэлтэй, мэдээллийг цаг хугацаанд нь байршуулсан чанарын үзүүлэлт **97.65** хувь буюу “**бүрэн хэрэгжсэн**” үнэлгээтэй байна.

Шилэн дансны цахим хуудаст Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд 2024 оны I улирлын байдлаар 12 төрлийн 2385 мэдээллийг хуулийн хугацаанд нь бүрэн мэдээлж байршуулжээ.

“Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг чанарын үзүүлэлтээр нь дүгнэхэд “бүрэн хэрэгжсэн” 51 байгууллага, харин “хэрэгжих шатанд” үнэлгээтэй 2 байгууллага байна.

### ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

<sup>1</sup> шилэн дансны хөтлөлт.

<sup>2</sup> Дотоод аудитын алба нь улирлын нэгдсэн тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа сарын 25-ны дотор хүргүүлнэ.

<sup>3</sup> Төсвийн ерөнхийлөн захирагч (дотоод аудитын алба) нь Шилэн дансны тухай хуулийн 8.2-т заасны дагуу шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

<sup>4</sup> Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл

